**Самбар 1** **Монгол орны мод сөөг** Эмхэтгэсэн: Манфред Веспер, Любек

| Lärche | Шинэс | Larix sibirica |
|---|---|---|
| Герман нэршил | Монгол нэршил<br>Монголд 1 зүйл | Зүйлийн латин нэршил |








**Тодорхойлолт:**

Монгол орны ойн гол төлөөлөгч болох шинэс нь нийт ойн 60 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд мод, модон бүтээгдэхүүний голлох түүхий эд юм. Бараг бүхий л нутгуудаар тархан ургах ба голын хөндийгөөр ургасан шинэснүүд илүү бахим, хүчирхэг байна. Нэг гэртэй, 5-р сард цэцэглэж 2 долоо хоногт соёолно, соёололт 60%, үрээс 5-7 ширхэг нахиа цухуйна.

Онцлог шинж: Намар болоход шилмүүс нь унах ба ингэснээр өвлийн хуурай, хүйтэн цаг уурын нөхцөлд ус чийгээ уршуулалгүй хадгалан үлддэг.

**Мэдээлэл:** 100 гаруй насалж, дунджаар 20 метр хүртэл өндөр ургана. Мод хоорондын зай 2 метрээс доошгүй байвал зохино. Барилга байшинтай хэт ойр зайд тарьж болохгүй!

**Грайфсвалдын Их Сургуулийн гербари** http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora_search=Taxon&action=species&gen=Larix

Дэлгэрэнгүй мэдээлэл, тархалтын зураг болон бусад зургуудтай дээрх холбоосоор орж танилцана уу.